



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 0125

Хараат

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой  
микробиологийн аргаар тэмцэх ажлыг  
зохион байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.10, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Бэлчээр хамгаалах өдөр 185 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/218 дугаар захирамжийг тус тус үндсэлэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг 1, 2, 3, 4 дүгээр багийн нутагт дэвсгэрт 3 тн бактержуулсан бэлдмэлийг 2023 оны 04 дүгээр сарын 15-25-ны хооронд 10 хоногийн хугацаанд багтаан явуулсугай.

2. Тухайн ажлыг зохион байгуулахдаа “Бэлчээр хамгаалах өдөр”-тэй холбогдуулан зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, албан байгууллага, иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж, бэлчээрт үр дүнтэй ажил зохион байгуулахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг сумын хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: - Н.Батгэрэл (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: - Д.Зулцэцэг (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Гишүүд:  
- Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)  
- Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)  
- Ц.Ундрахбаяр (3 дугаар багийн Засаг дарга)  
- Б.Балжинням (4 дүгээр багийн Засаг дарга)

- М.Доржсүрэн (Тамгын газрын нярав)

4.Микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах, үлийн цагаан оготной тэмцэх бэлчээрийн газрын мэдээллийг малчдад өгч, татан оролцуулах хяналт тавин ажиллахыг Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Байгаль орчны мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Дөрвөн багт ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

6.Дээрх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө батлуулан, шаардлагатай техник хэрэгсэл, бензин шатахууныг хариуцан цаг агаарын саатлаас бусад тохиодолд ажил саатахгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Батгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

